

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
01 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 28 өргөдөл бичгээр хүлээн авч бүрэн шийдвэрлэсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газарт 11 өргөдөл бичгээр хүлээн авч, 10 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 5 өргөдөл хүлээн авч хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласав.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 2 сувгаар 21 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 17, биечлэн 4 иргэн санал, гомдол ирүүлснээс талархал 1, гомдол 12, санал хүсэлт 8 тус тус бүртгэж, холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэсэн.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 1 дүгээр сард улсын төсвөөс авах санхүүжилт бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардал, ОНХС, ОНХО-ын зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгов.

Төсвийн гүйцэтгэлийн 2017 оны орлогыг Сангийн яамны орлогын хяналтын төлөвлөгөөгөөр 8,9 тэрбум төгрөг оруулахаас 9,8 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлж төлөвлөгөөг 114 хувиар биелүүлж ажиллав.

Орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөгөөр 9234,5 сая төгрөг оруулахаас 9631,2 сая төгрөг орж, төлөвлөгөө 396,7 сая төгрөгөөр буюу 4,3 хувиар, үүнээс татварын орлогоор 8366,4 сая төгрөг орохоос 8703,9 сая төгрөг орж, төлөвлөгөө 337,5 сая төгрөгөөр буюу 4 хувиар, татварын бус орлогоор 728,0 сая төгрөг орохоос 888,2 сая төгрөг оруулж төлөвлөгөө 160,2 сая төгрөгөөр буюу 22 хувиар тус тус давуулан биелүүлэв.

Хөрөнгийн орлогод 140,0 сая төгрөг оруулахаас 59,0 сая төгрөг оруулж төлөвлөгөө 80,9 сая төгрөгөөр тасраад байна.

Орон нутгаас улсын төсвийн орлогод 2220,0 сая төгрөг оруулахаас 2406,2 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 8,0 хувиар давуулан биелүүлсэн.

Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 8740,7, ТЗШ-гээр 40172,5, ОНХС-ийн орлогын шилжүүлгээр 1778,3, нийт 50691,5 сая төгрөг авахаас бүрэн авав.

Орон нутгийн болон орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн урсгал зарлага 62872,0 сая төгрөгт хүрч төсөвлөснөөс 1400,0 сая төгрөгөөр дутуу гарсан урьдчилсан дүнтэй байна.

Төсвийн өр 55,4 сая, авлага 60,7 сая төгрөг гарсан нь өмнөх оноос ОН-ын удирдлагыг хэрэгжүүлэх салбарын өр 21,3 сая төгрөг гарсан нь 97,2 сая төгрөгөөр, БСС-ын өр 26,5 сая төгрөг гарсан нь 47,9 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн салбарын өр 7,5 сая төгрөг гарсан нь 8,7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1778,3 сая төгрөг, замын сангийн хөрөнгө оруулалтаар 401,5 сая төгрөг нийт 2179,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээс бүрэн хэрэгжсэн байна.

Орон нутгийн 2018 оны төсвийн төлөвлөгөөг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх үүднээс аймгийн болон шилэн дансны вэб сайтад хуулийн хугацаанд байршуулж мэдээллээ.

Сумдын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт 2017 оны жилийн эцсийн тайлан гаргах, тайлангийн нэгтгэл хийх, тушаах талаар хэлтсийн даргын 110 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлжээ. Орон нутгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан авах ажлын хэсгийг байгуулж, хуваарь, тойрох хуудас гарган нягтлан бодогч нарт хүргүүлж ажиллав. Мөн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бололвсруулан Э-тайланд шивүүлэх талаар сум, байгууллагын нягтлан бодогч нарт зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласнаар 257 тайлангаас 72 тайлан хугацаандаа шивэгдэж, 28 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 1 дүгээр сард Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэг, ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийв. Шалгалтаар тогтоол, журам зөрчиж мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон, төсвийн тухай хууль зөрчиж төсөвт суугаагүй цалин хөлс олгосон, тушаал шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон, цалин хөлсийг ээлжийн амралттай байх хугацаанд давхардуулан олгосон, зарим ажилтныг буруу сүлжээ шатлалаар цалинжуулсан, сахилгын шийтгэлтэй ажилтнуудад ур чадвар, үр дүнгийн нэмэгдэл олгосон, анхан шатны баримт дутуу байхад гүйлгээ хийсэн, ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон, түрээсийн орлогыг тайлан балансад тусгалгүйгээр зарцуулж Төсвийн тухай хууль зөрчсөн, Боловсролын тухай хууль зөрчиж тэтгэмж олгосон зэрэг зөрчлүүд нийтлэг гарсан ба шалгалтаар нийт 4.8 сая төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр акт тогтоов.

Статистикийн хэлтэс нь өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг Жаргалант сумын Тахилт, Баатархайрхан, Булган сумын Далт, Эрдэнэбүрэн сумын Баянгол, Дөргөн сумын Агваш, Чандмань сумын Жаргалант багуудад, Жаргалант сумын Буянт, Булган сумын Далт, Мянгад сумын Цагаанбулан багийн нийт 88 өрхөд хийж, судалгааны материалаа хянан шивж байна.

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа дэлгэрэнгүй асуулгатай болж, судалгаанд хамрагдах нэгжийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулан 1 судлаачийн орон тоо нэмэгдсэн.

2017 оны 4 дүгээр улирлын 35 төрлийн мэдээг 820 аж ахуйн нэгж байгууллагаас гаргуулан авч программын хүрээнд шивж графикт хугацаанд нь Үндэсний Статистикийн хороонд хүргүүлэв. Мөн 2017 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулгыг урьдчилсан байдлаар гаргаж холбогдох хэлтэс, газрын удирдлагууд болон мэргэжилтнүүдэд цаасаар болон файлаар хүргүүлжээ.

Үндэсний Статистикийн хороо, аймгийн Биеийн тамир спортын газрын хамтарсан ажлын хэсэг Биеийн тамир, спортын улсын нэг удаагийн үзлэг, тооллогын материалыг 7 хоногийн хугацаанд шивж баталгаажуулав. Уг тооллогод аймгийн хэмжээний 657 спортын цол зэрэгтэй тамирчин, 34 заал танхим, 43 гадаад талбай хамрагдав. Мөн Аж үйлдвэрийн нэгдсэн тооллогын хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 233 аж ахуйн нэгжийн жагсаалтыг гаргав.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Хэлтсийн хурал 4 удаа хуралдаж, 9 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 2 иргэнд анхан шатны бичиг баримт боловсруулах тусламж үзүүлэв.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Хуулиа мөрдөө-21” арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Цагдаагийн газар хамтран Жаргалант сумын хэмжээнд архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгжүүдийн дарга, эрхлэгч, ажилчдыг хамруулан “Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэе” сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Архивын лавлагаа магадлагааг 173 хүн олгосон ба үүнээс 56 хүнд хуулбар, 66 хүнд цалингийн тодорхойлолт, 51 хүнд холбогдох баримт олдоогүй лавлагааг тус тус олгов. Баримтыг цахим санд оруулах ажлын хүрээнд 3 хөмрөгийн 3 дансны 1953-1993 оны 48 ширхэг хадгаламжийн нэгж буюу 4799 ширхэг хуудсыг цахим хэлбэрт оруулж ажиллав.

Цагдаагийн газар: Тус газраас тайлант сард иргэд олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах зорилгоор доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Улсын хэмжээнд зохион явагдсан “Хайрла хамгаал” аяны хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл, архидан согтуурах явдлаас урьдчилан сэргийлэх, эцэг эх, үр хүүхэд, гэр бүлээ хайрлан хамгаалах чиглэлээр 10 төрлийн богино хэмжээний шторкийг бэлтгэн орон нутгийн 2 телевизээр 7 хоногт 3 удаа нэвтрүүлж, цахим сүлжээгээр олон нийтэд хүргэсэн.

Хүний эрхийг зөрчсөн, ёс бус гэмт үйлдлүүд цахим ертөнцөөр нилээдгүй тархаж байгаатай холбогдуулан кибер халдлага, цахим ертөнц дэхь хүний эрх, гэмт хэргийн хохирогч болохоос хэрхэн урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт хэлэлцүүлгийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

“Хуулиа мөрдөө-21”, “Сэрэмжилье нэгдье” арга хэмжээнүүдийн хүрээнд Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн нийт бие бүрэлдэхүүн, ерөнхий боловсролын Цаст-Алтай, 1, 3, 7 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчид, Политехник коллежийн 1, 2 дугаар дотуур байрны нийт 415 хүнд “Хулгайн гэмт хэргийн тухай ойлголт”, “Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх нь”, “Архидан согтуурахын хор уршиг, түүнээс сэргийлэх нь” сэдвээр тус тус сургалтыг зохион явууллаа.

Арга хэмжээний удирдамжийн дагуу архины хор хөнөөл, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 37 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлгийг цахим сүлжээнд нийтлүүж, 10 төрлийн шторк бэлтгэн олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэсэн.

Зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийг сурталчилах зорилгоор ХААН банкны Ховд салбартай хамтран хөдөлгөөнд оролцож буй жолооч нарын дунд “Сайн жолооч” теле нэвтрүүлгийг зохион явуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилав.

Мөн бага насны хүүхдэд замын хөдөлгөөний дүрмийн анхан шатны мэдлэг олгох зорилгоор 1 дүгээр сургуулийн багш, ажилчдад яриа таниулга хийж, тус сургуулийн шатанд аюулгүйн тэмдэг тэмдэглэгээ хийхэд нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Жаргалант сумын Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/96 дугаар захирамжийн дагуу 9 байгууллагын 22 ажилтан Цагдаагийн газрын алба хаагчдын хамтаар гудамж талбай, олон нийтийн газарт эргүүлийн үүрэг гүйцэтгэж ажилласан.

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг буурч байгаа боловч байгууллага, аж ахуйн нэгжийн харуул хамгаалалт сул, хувийн өмчийн хадгалалт хамгаалалт хангалтгүйгээс хулгайн эзлэх хувь нэмэгдэж, гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд учирсан хор хохирол ихэсч байгаад бүх нийтээрээ анхаарах шаардлагатай байгаа талаар 113 байгууллага аж ахуйн нэгж, шатахуун түгээх станцуудад албан мэдэгдэл хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны 01 дүгээр сарын 25-ны байдлаар нийт 32 гэмт хэрэг бүртгэгдэж, зөрчил гаргасан нийт 141 хүнийг албадан саатуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, жижгээр танхайрсан зөрчилд 8 хүнийг 7-30 хоногийн хугацаатайгаар баривчлуулж, 26 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, зөрчил гаргасан 545 хүнийг 40.196.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авч ажилласан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар – 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны А/14 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор ангийн даргын 2018 оны А/04 дүгээр “Хоригдогсдыг нүүлгэн шилжүүлэх тухай”, мөн өдрийн А/05 дугаар тушаалаар “Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжих үеийн хамгаалалт зарлах тухай” ажлын хэсэг байгуулан, батлагдсан төлөвлөгөөний дагуу цагдан хорих байрнаас шинэ цагдан хорих байранд хоригдогч этгээдийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг тус анги болон цагдаагийн газрын 57 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг, зөрчилгүй зохион байгуулан ажиллалаа.

Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, цэрэгжилч, жагсаалч байдлыг хангах, ажлын цаг ашиглалт, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ажил эхлэх, дуусах цагуудад нэгтгэн жагсааж бүртгэн, ажлын цаг ашиглалтанд хяналт тавьж ажилласан ба 7 хоногийн Баасан гарагт нийт бүрэлдэхүүнийг хичээл, сургалт, мэдээлэл хийж, жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан ажиллаж байгаа бөгөөд Монгол улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан

даалгаврын хэрэгжилтийн хүрээнд төлөвлөгөө гарган ангийн даргаар батлуулан ажиллаж байна.

Хорих ангийн харуул хамгаалалтыг “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-ын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд ангийн даргын тушаалаар онцгой учралын үед ажиллах төлөвлөгөөг сар бүр шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн шуурхай бүлгийн алба хаагчдыг томилуулан ажиллуулж, эргэн шалгах төлөвлөөний дагуу тус ангийн тасаг нэгжүүд шөнийн болон өдрийн цагаар харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын үүрэг гүйцэтгэлтийг шалган гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчилөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Болзошгүй ажиллагааны үед ашиглагдах Тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн алба хаагчдад өдөр бүр бичгээр үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавин ажиллав.

Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн үйл ажиллагаа хууль, журмын дагуу хэвийн явагдаж байгаа бөгөөд хоригдол, хоригдогч нарын дундаас ямар нэгэн гэмт хэрэг зөрчилгүй тайван байгаа болно.

Шүүхийн шинжилгээний алба: Шүүхийн шинжилгээний албанд 27 албан бичиг, 64 шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж ирснийг хүлээн авч, цаг тухайд нь шийдвэрлэж, байгууллагаас 33 албан бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэв.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 8 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 87 хүнд, бэлгийн холбогдолтой 1, хавтаст хэргийн материалаар 2 шинжилгээ химийн шинжилгээ 40, биологийн шинжилгээ 30, криминалистикийн шинжилгээ 10 тус тус хийж, нийт 178 дүгнэлт гаргаж, алсын дуудлаганд криминалистикийн шинжээч, шинжээч эмч, туслах ажилтан нар 3 удаа явж үүрэгт ажлаа гүйцэтгэв.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 51 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 11 ширхэг мөр, гутлын мөр 14, тээврийн хэрэгслийн мөр 35, бусад ул мөр, эд мөрийн баримт 62-ыг илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 85 тус тус авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийв. Криминалистикийн шинжээч нар гэрэл зургийн ажил 1119 хийснээс шинжилгээний 94, хэргийн газрын үзлэгийн 626, цогцосны үзлэг задлан шинжилгээний 245, бусад 154 тус тус хийж, цагдаагийн байгууллагад хүргүүлсэн. Гарын дардас 82, гарын мөр 21-ээр санг баяжуулав.

Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох, бүтцийн болон химийн, биологийн, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүдийг тухай бүр нь цахимжуулав.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тайлант сард нийт 2533 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 1838, аймгийн хэмжээнд шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэн 565 байгаа ба шилжин ирсэн иргэд 84, шилжин явсан иргэд 62, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 419, гадаад паспорт олголт 230, иргэний үнэмлэх шинээр олгосон 78, сунгалт 142, дахин олгосон 66, иргэний бүртгэлийн лавлагаа 475 олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 282 бүртгэлийг хийв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 601, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 79 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлэв.

Иргэдээс нийт 15 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс 10 өргөдөлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 2 өргөдлийг холбогдох байгууллагад шилжүүлж, 3 өргөдлийн хугацаа болоогүй байна.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: Боловсрол соёл урлагийн газрын алба хаагчдын тайлант сард зохион байгуулах ажлын саналыг хэлэлцүүлэн 20 ажлыг хийхээр төлөвлөж, 31 ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Хүүхэд, залуучууд уншсан номоос суралцах, бүтээлчээр унших, сурагчдад мэдлэг оюун ухаанаа хөгжүүлэх, эсээ бичих арга зүйд суралцуулах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Ном-миний найз” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг Боловсрол, соёл, урлагийн газраас 2 үе шаттайгаар зохион байгуулсан ба шалгарсан эхний 3 материалыг дараагийн шатанд оролцуулсан бөгөөд Алтай, Булган сумын 1, Минжит Булган цогцолбор сургууль, Буянт, Дуут, Дөргөн, Зэрэг, Манхан, Мөст, Чандмань, Ховд, Эрдэнэбүрэн сумын сургууль, Жаргалант сумын 2, 3, Прогресс сургуулийн 40 сурагчийн материал ирж, эсээг шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын хэсэг үнэлж шалгарууллаа.

Хүүхдийн хөгжлийг дэмжсэн, хүүхдэд зориулсан бүтээлийн сантай болох, сургалтын материаллаг орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийг хүүхдэд зориулсан ном бүтээх, бүтээлч үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор багш, эцэг эхчүүдийн дунд “Хүүхдэд зориулсан ном бүтээх уралдаан”-ыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас сургуулийн өмнөх болон сургуулийн нас 2 ангиллаар зохион байгуулж, сургуулийн насны ангилалд Булган сумын 1 дүгээр сургууль, Дуут, Манхан, Мөст, Үенч, Чандмань, Эрдэнэбүрэн сумын сургууль, Жаргалант сумын 1, 3, Прогресс сургуулиудаас 58 бүтээл, сургуулийн өмнөх насны ангилалд Булган, Дуут, Дарви, Үенч, Ховд сумын цэцэрлэг, Жаргалант сумын 1, 2, 3, 4, 5, 7, 8, 12, 14 дүгээр цэцэрлэгийн 64 бүтээл нийт 122 бүтээл ирүүлж, ахмад, ЕБС, СӨБ-ын багш нар төрөл бүрийн үддэг, товчилдог, уядаг, хэлхдэг, наадаг, ялгадаг, нэрлэдэг гэх мэт хүүхдийн гарын жижиг булчин хөгжүүлэх, танин мэдэхүй, оюун ухааныг хөгжүүлсэн эсгийн, даавуун, хэвлэмэл ном, үлгэр, шүлэг, оньсого, төрөл бүрийн сэдвийн хүрээнд ном бүтээснийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж урамшууллаа.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/287 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж хоёр, гурав, дөрөв дэх жилдээ ажиллаж буй багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтанд хамрагдагсдын бүртгэлийг онлайнаар хийж, тэдний хэрэгцээнд тулгуурлан нийт 113 багшид хүүхэд бүрт хүрч ажиллах тэднийг хөгжүүлэх арга зүй технологийг эзэмших сургалтыг 113 багшид зохион байгуулсан. Тус сургалтад 2 дахь жилдээ ажиллаж буй 29, 3 дахь жилдээ ажиллаж буй 38, 4 дэх жилдээ ажиллаж буй 48 багш бүртгүүлж, хамрагдав.

Мэдээлэл харилцааны технологийг сургалтад ашиглах нь мэргэжлийн багш нарт илүү сонирхолтой байсан тул энэ чиглэлээр сургалтын идэвхтэй аргуудыг хэрэглэх нь зүйтэй гэж оролцогчдоос санал гаргав.

Ерөнхий боловсролын дунд сургууль болон цэцэрлэгийн эмч нарт сүрьеэ өвчний хууль тогтоомжийн өнөөгийн байдлын талаар сургалт зохион байгуулж, сүрьеэ өвчин, эрүүл мэндийн хууль тогтоомж, ажлын байран дахь сүрьеэ өвчний хамгаалалтын талаар мэдээлэл өгөв. Мөн Жаргалант сумын цэцэрлэгийн багш нарт тогтвортой хөгжлийн боловсрол-сургуулийн өмнөх боловсролд сэдвээр сургалт зохион байгуулж, тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлал, хэрэгжүүлэх арга зам, ногоон хөгжил, эко цэцэрлэгийн үзэл санааны талаар харилцан санал солилцов.

Сурагчдын эрүүл мэндэд анхаарч тэдний сахин хамгаалах зорилгоор Жаргалант сумын 15 цэцэрлэгийн 130 багш, ажилчдыг томууны эсрэг вакцинд хамрууллаа. Мөн сүрьеэгийн урьдчилсан сэргийлэх үзлэгт аймгийн төвийн цэцэрлэг, сургуулийн 545 багш, ажилчдыг үнэ төлбөргүй хуваарийн дагуу хамруулж байна.

Монгол хэл бичгийн сургалтын чанарыг дээшлүүлэх хүрээнд 2-12 дугаар ангийн сурагчдаас авах монгол хэлний хөндлөнгийн үнэлгээний сэдвийг боловсруулан сургуулиудад хүргүүлээ.

Соёлын төвийн хөгжмийн багш нарын сургалтыг 2018 оны 01 дүгээр сарын 15-19 ны өдрүүдэд зохион байгуулж Сургалтаар хөгжмийн багш нарын онолын мэдлэгийг дээшлүүлж, ард иргэдэд соёлын үйлчилгээг мэргэжлийн түвшинд, чанартай хүргэх, шавь сургалтыг өөрийн сонсгол мэдрэмжид биш онол арга зүйд тулгуурлан зохион байгуулах чадварыг эзэмшүүлэв.

Боловсролын салбарын тоон мэдээллийн нэгтгэлийг www.khovd.meds.gov.mn цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулав. 2017-2018 оны хичээлийн жилийн ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоон мэдээллийн нэгтгэлээр боршур гаргаж олон нийтэд түгээв.

Төрийн өмчийн 31 цэцэрлэг, хувийн өмчийн 13 цэцэрлэгийн хүүхдийн нарийвчилсан бүтэцтэй ажиглалт хийсэн үнэлгээг Лакол программд шивж, үнэлгээний газарт хүргүүлээ.

Норвегийн тусламжийн байгууллага хүүхдийн эрх- хөгжил-2 төслийн 2018 онд хамтран ажиллах төлөвлөлтийн хуралд оролцож, БСУГ-аас дотуур байрны багш ажилчдыг чадавхжуулах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар болов.

Япон улсын засгийн газраас Ази номхон далайн орнууд болон Япон улсын хүүхэд залуучуудын харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор 2007 оноос хэрэгжүүлж байгаа JENESYS хөтөлбөрийн хүрээнд Жаргалант сумын 7 сургуулийн 8 хүүхдийн тодорхойлолт ирж, Цаст-Алтай цогцолбор сургуулийн 12 дугаар ангийн сурагч шалгарч Япон улсад суралцахаар боллоо.

Анли хэлний боловсролын үндэсний хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын Энх тайвны корпусын сайн дурын ажилтнуудтай хамтран Англи хэлний ярианы клуб

хичээллүүлэв. АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Иргэн төслийг 10 сургуулиудад хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслийг хэрэгжүүлэгч Иргэний боловсролын төвийн хөтөлбөрийн захирал аймагт ажиллаж төслийн хэрэгжилтийн явцын талаар арга зүйн зөвлөмж өгсөн ба төслийн үйл ажиллагааг баримтжуулж багш сурагчдаас ярилцлага авч видео бичлэг хийж санхүүгийн бичил дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулав.

Соёл, Спортын чиглэлээр: Төрийн шагналт Ардын жүжигчин Ж.Чулууны нэрэмжит Алтангадас одонт Хөгжимт драмын театр нь байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, дотоод журмыг шинэчлэн баталж, 2018 оны ажил, уран бүтээлээ эхлүүллээ. Уран бүтээлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уран бүтээлчийн бие даасан тайлан тоглолтыг зохион байгуулж, гадны 5 үйл ажиллагааны 1200 үзэгчдэд соёл урлагийн үйлчилгээг хүргэв.

Аймгийн Нийтийн номын сан тайлант сард 46 уншигчдад шинээр карт нээж 592 ирцэд 1044 ном, сонин хэвлэл олгож үйлчиллээ. Номын сангийн 2018 оны 1 дүгээр сард хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж, ажилтан ажилчдын ажлын байрны тодорхойлолт шинэчлэн, хөдөлмөрийн гэрээг байгууллаа. Номын сангийн статистик СУ-3, СУ-10, СУ-15 мэдээ судалгааг гаргаж аймгийн Статистикийн хэлтэс, БСУГ, Үндэсний номын санд хүргүүлэв. Номын үзэсгэлэн 4, Америк соёл мэдээллийн төв ганцаарчилсан лекц 3, сургалт 2 удаа, уралдаан тэмцээн 1 удаа тус тус зохион байгуулж нийт 800 гаруй иргэдэд үйлчлэв.

Аймгийн Музей нь угсаатны танхимын үзмэрийн дэглэлтийг шинэчлэн, хадгалалт хамгаалалтыг сайжрууллаа. Мөн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаж батлууллаа. Аймгийн ИТХ-аас 1,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар АИХ-д сонгогдож байсан депутатуудын алдрыг мөнхжүүлэх булан байгууллаа.

Биеийн тамир спортын газар 2018 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ. Үүнд: Биеийн тамир спортын газрын даргын баталсан 2018 оны сургалт бэлтгэлийн хуваарийн дагуу спортын 10 төрлөөр 550 гаруй тамирчин сурагчид бэлтгэл сургуулилтанд хамрагдаж, тус бэлтгэл 1-5 дахь өдрүүдэд өглөө, өдөр 2 ээлжээр хичээллэж байгаа бөгөөд бүс, улсын чанартай тэмцээнүүдэд бэлтгэгдэж байна.

“Ховд-2018” Идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнийг 2018 оны 01 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж, тэмцээнд Жаргалант сум, хөдөө сумдын 21 ерөнхий боловсролын сургуулиудын эрэгтэй 21, эмэгтэй 20 баг хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж аваргуудаа тодруулан бүс, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдаа сонгон шалгаруулав.

Аймгийн Биеийн тамир спортын газраас 2018 оныг “Нийтийн биеийн тамирыг эрчимжүүлье” жил болгон зарлаж, байгууллагын багш, дасгалжуулагч, ажилчид тус онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө батлуулан Хөдөлмөрийн гэрээ байгууллагын даргатай байгууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: Тайлант сард салбарын ажлын өмнөх онд хийсэн ажлын тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх, байгууллагын удирдлагууд, ажилтнуудын үр үнгийн гэрээг дүгнэж, 2018 оны гэрээ байгуулах, зудын байдлын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлд анхаарч ажиллаа.

Хүний нөөцийн тайланг бүх сум, өрх, хувийн хэвшлийн нийт 73 байгууллагаас цахим болон цаасан хэлбэрээр авч нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд Hinfo3 программд шивж хүргүүлэн нийгмийн эрүүл мэндийн тайланг яаманд бичмэлээр хүргүүллээ.

Хэвтүүлэн эмчлэх эрх бүхий төрийн эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулан 35 багцаар 17 компани саналаа ирүүлж, 14 компани шалгарч нийт 1.2 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээгээр нийлүүлэхээр компаниудтай гэрээ байгуулах ажлыг эхлүүлээд байна.

ЭМС-ын 2011 оны “Вакцины тухай” 122 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор 12 дугаар сарын болон жилийн эцсийн дархлаажуулалтын хамрагдалт болон зарцуулалтын тайлан гаргаж, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанд хүргүүлж, 7 хоног тутмын халдварт өвчний мэдээллийг 2 удаа бэлтгэн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, холбогдох байгууллагуудад хүргүүллээ

2018 оны 1 дүгээр улиралд хэрэглэгдэх 12 нэр төрлийн 20.1 сая төгрөгийн үнэ бүхий вакцин, биобэлдмэлийг дархлаажуулалтын албанаас захиалан авч дархлаажуулалт бүхий цэгүүдэд хүргүүлж, хамралтыг 99.6 хувьтай гүйцэтгэснээр дархлаажуулалт бүхий халдварт өвчин бүртгэгдсэнгүй.

Аймгийн хэмжээнд үйл ажилагаа явуулж буй Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2017 оны гурвалсан гэрээг дүгнэж, төвүүдийн дарга нартай хэлэлцүүлэг зохион байгуулж, 2018 оны гэрээний төслийг хийж бэлтгээд байна.

Аймгийн хэмжээнд өвөлжилт хүндэрч, цас зуд ихтэй, 12 сум зудын байдалтай байгаа бөгөөд одоогийн байдлаар 3856 иргэн, 5 нярай, 5 хүртэлх насны 634 хүүхэд, 46 жирэмсэн эх, 65-аас дээш насны 281 иргэн өөр аймаг, сумдад нүүдэллэн амьдарч байна. Эдгээр өрх, иргэдэд тусламж үйлчилгээг хүргэх зорилгоор 12 сумдаар эмч нарын үзлэгийн баг ажиллуулахад 2.5 сая, сумдын эм авах боломж муутай эмзэг, олон хүүхэдтэй 510 өрхөд 5.1 сая төгрөгийн эмийн багц хүргэж, өрх тус бүрд 200 000 төгрөг, хүүхдийн тасгийн амбулаторийн үйлчилгээний зардалд 1 сая, БОЭТ-ийн зүрх судас, дотрын тасгийн халаалт дулаан тохижилтын засварт 9 сая, 27.6 сая төгрөгийн дэмжлэгийг онцгой комиссын шийдвэр гаргуулан тусламж үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүллээ.

2017-2018 оны өвөлжилт хүндэрч байгаатай холбоотойгоор Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламжийн газарт 14 хоног тутамд Эрүүл мэндийн салбарын өвөлжилтийн бэлэн байдлын мэдээг 16 сум, 6 өрхөөр гаргуулан нэгтгэж jannatumuruuya@gmail.com хаягаар хүргэж байна.

Томуу, томуу төст өвчний дэгдэлт нэмэгдэж нийт амбулаторийн үзлэгийн 15.7 хувийг эзэлсэн тул Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яаманд санал хүргүүлэн сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг 14 хоногоор хааж, нийтийн үзвэр үйлчилгээ цуглааныг хязгаарлах арга хэмжээ авч, эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагаар ажиллуулан, зорилтот бүлгийн үзлэгийг гэрийн үзлэгийн хэлбэрээр хүргэснээр өвчлөлийн дэгдэлтийг богино хуугацаанд бууруулж чадлаа.

Тав: Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Аймгийн Мал эмнэлгийн хэлтэс нь Мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 2018 онд хамрагдах мал, түүнд шаардагдах био бэлдмэл, төсөвт зардлыг тооцон өвчний гаралт, тархалтын судалгааг нэгтгэн УМЭҮГ-т хүргүүлэв.

2012-2017 оны халдварт өвчний судалгааг сум тус бүрээр түүвэрлэн гаргаж Зоонооз өвчин судлалын төвд хүргүүлэв.

Дэлхийн зөн ОУБ, Мерси Кор Монгол олон улсын байгууллагын Ховд аймаг дахь төлөөлөгчийн газраас зохион багуулсан өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн төсөл цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдтэй танилцах сургалтуудад МЭА-ны эмч мэргэжилтнүүд хамрагдав. Мерси кор олон улсын байгууллагаас USAID/OFDA-ийн Төлөөлөгч Ghrgstine Мерси кор Монгол ОУБ-ын МАА-н мэргэжилтэн Danill Mihher, “Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь 2 /LTS2/ төслийн менежер, Мерси кор ОУБ-ын хөтөлбөрийн орлогч захирал, Мерси кор Монгол ОУБ-ын Ховд аймаг дахь төлөөлөгч болон холбогдох хүмүүс хүнс, хөдөө аж ахуйн газрын эмч, мэргэжилтнүүдтэй уулзаж 2016 онд Ховд аймагт оношлогдсон Мязлан өвчний тухай, Мерси кор ОУБ-аас өмнөх жилүүдэд хэрэгжиж байсан төслүүдийн үр дүнгийн талаар харилцан ярилцаж, цаашид нэн шаардлагатай хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар танилцуулав.

Улсын Онцгой комиссын дарга, Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, ХХААХҮ-ийн сайд Б.Батзориг, ОБЕГ-ын дарга, хошууч генерал Т.Бадрал тэргүүтэй Шуурхай бүлэг баруун болон төвийн аймгуудын өвөлжилтийн нөхцөл, байдал, орон нутгийн Онцгой комиссын үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, өвс тэжээлийн хангамжийн байдалтай газар дээр нь танилцаж, аймаг, орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, өвөлжилтийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, гамшгаас хамгаалах улсын албадын бэлтгэл, бэлэн байдлыг шалган үүрэг чиглэл өгч ажиллав. Энэ үеэр аймгийн Онцгой комиссын өргөтгөсөн хурал хуралдаж, өвөлжилтийн нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцож яаралтай авах зарим арга хэмжээг авлаа.

Хүнс хөдөө аж ахуйн газрын халдварт өвчин судлалын холбогдох эмч мэргэжилтнүүд зудын үед МЭҮН-ийн малын эм бэлдмэлийн бэлэн байдалд хяналт хийж Зэрэг, Цэцэг, Булган, Үенч, Мөст, Мөнххайрхан, Дарви бусад сумдад ажиллаж эмийн нөөцийг бүрдүүлэн ажиллах талаар заавар зөвлөмж өгөв. МЭОАЦЛ-ийн Ариун цэврийн тасаг нь хүнсний захад худалдан борлуулагдаж байгаа болон зах зээлд нийлүүлэгдэж байгаа 9240 кг махны 423 дээж, 4860 л сүүний 150 дээж, 500 гогцоо

өлөн, 50 ш өндөг, 1210 ш арьс шир, МЭАЦ-н стандартын дагуу шинжилгээ хийж, 60 толгой малд эрүүл мэндийн үзлэг хийж, 1280 м/кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Ийлдэс судлалын тасаг Буянт, Манхан, Мянгад, Эрдэнэбүрэн сумдын 460 хуц, ухны дээжинд /ЭЛИЗА/ аргаар шинжилгээ хийхэд 95 дээж эерэг дүн үзүүлснийг дахин баталгаажуулах шинжилгээ хийв.

Мал аж ахуйн алба нь “Улсын аварга малчин”, “Алтан төлийн эзэн”-ээр тодорхойлогдсон малчдын тодорхойлолтыг болзол журмын дагуу Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд уламжлав. Мөн аймгийн аварга малчин, хошой аваргаар тодорхойлогдсон малчдын тодорхойлолтыг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу арьс, шир бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан 17 сумын малчин, мал бүхий иргэдийн материалыг хүлээн авч Мал хамгаалах санд хүргүүлэхэд бэлэн болгоод байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2018 оны А/01 тушаалаар өвөлжилт, хаваржилтын байдал болон бусад гамшигт үзэгдлийн шуурхай мэдээ сумдаас хүлээн авах, ХХААХҮ-н Яаманд мэдээлэл хүргэх үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг 2018 оны 01 дүгээр сарын 10-наас эхлэн 05 дугаар сарын 01 хүртэл өглөө 08 цаг 00 минутаас оройн 20 цаг 00 минут хүртэл 12 цагаар ажиллуулж эхлээд байна. Хариуцлагатай жижүүр нь сумдаас 70433089 утсаар цаг үеийн байдлийн талаар мэдээлэл авч нэгтгэн ХХААХҮ-н Яамны 263247 утсанд мэдээлэл хүргэж байна.

Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг зудад нэрвэгдсэн 12 суманд тус бүр 600 боодол өвс, 200 уут тэжээлийг аймгийн онцгой комиссын шийдвэрээр хүргүүлээд байна.

Зургаа: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар: Аймгийн Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.6, 9.7, 9.8, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн дагуу “Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид өгөх хэрэглэгчийн үнэлгээ”-г төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулах зарыг Ховд, Жаргалант, Олон ястны телевизүүдээр зар мэдээлэл хийж, Ухаалаг хөгжил, Сурах чадварыг хөгжүүлэх төв, Хэвлэлийн хүрээлэнгийн баруун бүсийн төв, Ховдын толь төрийн бус байгууллага, Усалгаатай газар тариалан эрхлэгчдийн холбоо, Баруун бүс нутаг судлал НҮТББ, Баруун бүсийн тогтвортой хөгжлийн хүрээлэнгүүдэд 2018 оны 2/57 тоот сонгон шалгаруулалт зарлах тухай албан бичиг болон Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамжийг хүргүүлэв.

Аймгийн ЗДТГ-ын даргын 2018 оны А/06 дугаар тушаалаар “Хэрэглэгчийн үнэлгээ” хийх төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулж, “Хэрэглэгчийн үнэлгээ” хийх төсөл сонгон шалгаруулалтад Хэвлэлийн хүрээлэн

баруун бүсийн төв ТББ, Сурах чадварыг бэхжүүлэх төв НҮТББ, Ховд их сургуулийн баруун бүсийн тогтвортой хөгжлийн хүрээлэн, Ховдын толь ТББ, Ухаалаг хөгжил-иргэдийн оролцоо ТББ-уудаас ирүүлсэн төслүүдтэй танилцаж сонгон шалгарууллаа.

Төрийн бус байгууллагуудаас “Ховд их сургуулийн Баруун бүсийн тогтвортой хөгжлийн хүрээлэн” шалгарч “Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжид өгөх хэрэглэгчийн үнэлгээ 2017” судалгааны тайланг гүйцэтгэхээр аймгийн Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулж, хэрэглэгчийн үнэлгээг гүйцэтгэж байна.

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг холбогдох хэлтэс, сум, байгууллагуудаас авч нэгтгэн, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, www.new.unelgee.gov.mn сайтад шивж баталгаажуулан, зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Мөн 2017 оны жилийн эцсийн байдлаар аймагт холбогдолтой хэрэгжүүлэх Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан 6 үндэсний хөтөлбөрийн 32 зорилт 81.3 хувь, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 28 үндэсний хөтөлбөрийн 131 зорилт 82.0 хувь, нийт 33 үндэсний хөтөлбөрийн 169 зорилт 82.0 хувьтай хэрэгжсэн дүнг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон холбогдох яамдад хүргүүлэв.

Үүнд: Гадаад харилцааны яаманд 2018 оны 1/79, Архивын ерөнхий газарт 2018 оны 1/95, Авлигатай тэмцэх газарт 2018 оны 1/92, Шадар сайдын ажлын албанд 2018 оны 1/94, 1/85, Хууль зүй дотоод хэргийн яаманд 2018 оны 1/93, БСШУСЯ-нд 2018 оны 1/84, Эрүүл мэндийн яаманд 2018 оны 1/82, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2018 оны 1/83, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2018 оны 1/86, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд 2018 оны 1/81, Барилга, хот байгуулалтын яаманд 2018 оны 1/80, Онцгой байдлын ерөнхий газарт 2018 оны 1/106 тоот албан бичгүүдээр тус тус хүргүүлэв.

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, дотоод аудитын газарт 2018 оны 1/131 тоот албан бичгээр Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэлийн хамт хүргүүлэв.

Улсын их хурал болон Засгийн газрын тогтоолоор
батлагдсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд
хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

(2017 оны жилийн эцсийн байдлаар)

Д/д	Салбараар	Хөтөлбөр-ийн тоо	Зорилт-ын тоо	Үнэлгээ
1	Нэг. Төрийн байгуулалт, гадаад харилцааны чиглэлээр	1	3	85.0
2	Хоёр. Хууль, эрх зүйн чиглэлээр	4	21	67.5

3	Гурав. Боловсролын чиглэлээр	1	4	85.0
4	Дөрөв. Соёл, урлагийн чиглэлээр	3	14	84.3
5	Тав. Эрүүл мэндийн чиглэлээр	6	32	87.7
6	Зургаа. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж үйлчилгээний чиглэлээр	3	16	86.8
7	Долоо. Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр	1	5	88.0
8	Найм. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр	6	41	82.6
9	Ес. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр	2	8	82.0
10	Арав. Дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга хот байгуулалтын чиглэлээр	3	16	72.0
11	Арван нэг. Онцгой байдлын чиглэлээр	2	11	83.5
12	Арван хоёр. Статистик	1	6	81.6
Дундаж үнэлгээ		33	169	82.0

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/02 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2018 оны 01 дүгээр сарын 09-22-ны өдрүүдэд 17 сум, 91 баг, 31 албан байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2017 оны жилийн эцсийн ажилд үнэлэлт дүгнэлт өгч ажиллав.

2018 оны 01 дүгээр сарын байдлаар Засгийн газрын 5 тогтоол, 2 хуралдааны тэмдэглэл хүлээн авч аймгийн удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллав.

Долоо: Сумдын мэдээлэл:

Жаргалант сум: Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг хангахад инженерүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын үйл ажиллагааг сайжруулах тулгамдаж буй асуудлыг хамтын хүчээр хэлэлцэн шийдвэрлэх, арга замыг тодорхойлох үүднээс “Инженерүүдээ сонсоё” хэлэлцүүлгийг нийт 80 инженерийг оролцуулан зохион байгуулсан.

Цэргийн шинэчлэсэн тоо бүртгэлийн үйл ажиллагааг 12 багийн хэмжээнд зохион байгуулж дүн мэдээг хуулийн хугацаанд цэргийн хэлтэст хүргүүллээ.

Жинст транс ХХК-тай хамтран тус сумын 12 багийн нийт 21 өрхөд 79 уут хорголжин тэжээлийг хямдралтай үнээр олгов. Сумын Засаг даргын 2018 оны А/17 тоот захирамжийн дагуу 4 ажлын хэсэг байгуулагдан тус сумын нутаг дэвсгэрт мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн нийлүүлж байгаа, мах, сүү, цагаан идээ худалдан борлуулж буй аж ахуйн нэгж, иргэдийн тооллого судалгааг гаргав.

Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг томилогдон “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Амьтны тухай”, “Хог хаягдлын тухай”, “Ойн тухай” Монгол улсын хууль болон, аймгийн Засаг даргын 2005 оны 171 дүгээр захирамжийн хэрэгжилтийн явц холбогдох хууль тогтоомж стандартуудын хүрээнд хэрэгжиж байгаад дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил

дутагдлуудыг арилгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал гаргах зорилготой хяналт шалгалтаар ажиллалаа.

Зэрэг сум: Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Бураа, Бургасан багийн малчин 45 айлаар орж 100 гаруй иргэнтэй биечлэн уулзаж өвөлжилтийн нөхцөл байдлын талаар мөн цаг үеийн мэдээ мэдээллийг малчин ард иргэдэд хүргэх, өвс тэжээлийн хүрэлцээний судалгаа авч, тэдний санал хүсэлтийг сонсож, сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч, багийн Засаг дарга, тус тойргоос сонгогдсон ИТХ-ын төлөөлөгч нар хамтран ажиллав. Ханиад томууны дэгдэлт их байсантай холбогдуулан сумын ЭМТ-ийн эрхлэгч эмч өндөр настан болон хүүхэд багачууд ард иргэдэд үзлэг хийж шаардлагатай эм бэлдмэлийг иргэдэд үнэ төлбөргүй олгов.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг 2018 оны 01 дүгээр сарын 21-ны өдөр тус суманд ажиллаж ард иргэдэд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилт, цаг үеийн мэдээ мэдээлэл өгөв. Сумын хэмжээнд цас ихээр орж өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан аймгийн Онцгой байдлын газар болон, аймгийн Засаг даргын Тамгын газраас санаачлан хэрэгжүүлж байгаа “Малчиддаа туслая” аяны хүрээнд нийт 1155 ширхэг пресс, 190 уут хивгэн тэжээл, 625 уут хорголжин тэжээлийг багийн Засаг дарга нараар дамжуулан малчдад олгохоор хүлээн авлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, нийгмийн амьдралд нь тусламж дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах” ажлын хэсэг сумын Засаг даргын 2018 оны А/80 дугаар захирамжаар байгуулагдаж сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд “Нээлттэй хэлэлцүүлэг” зохион байгуулж “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо”-г 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж холбооны даргыг сонгов. Тус хэлэлцүүлэгт сумын сумын удирдлагууд, сумын нийгмийн бодлогын ажилтан, нийгмийн халамжийн мэргэжилтэн, нийгмийн даатгалын байцаагч нар оролцож мэдээлэл өгсөн ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл 30 хүн оролцож өөрсдийн өмнө тулгараад байгаа асуудлын талаар санал бодлоо солилцов.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Хуулиа мөрдье-21”, Сэрэмжлээнэгдэе” сарын аяныг сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай хамтран хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган сумын Засаг даргаар батлуулан захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус аяны хүрээнд суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж дэлгүүрүүдэд 21 нас хүрээгүй хүүхдэд архи согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх, тамхи, ахуйн хэрэглээний газ, шар цавуу зэргийг худалдаалахгүй байх заавар зөвлөмжүүдийг хүргүүлж ажиллалаа. Мөн Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх-Хүүхэд хамгаалал”-ын сургалтыг зорилтот бүлгийн 25 өрхийн гишүүдийн дунд зохион байгуулав.

Тус сумын Эрүүл мэндийн төв 2018 оны 01 дүгээр сард нийт 236 хүнд үзлэг шинжилгээ хийж урьдчилан сэргийлэх үзлэгт 56, диспансерийн хяналтанд 45, гэрийн идэвхитэй эргэлт 34, амбулаторийн үзлэг 105, гэрийн дуудлагаар 28 хүнд тус тус

үйлчилж, 16 хүнийг 13А маягтаар дээд шатлалын эмнэлэгт шилжүүлсэн. Нийт 61 иргэн хэвтэн эмчлүүлсэн ба 383 ор хоног ашигласан. Түргэн тусламжийн дуудлага 22 гарснаас алсын 17 дуудлагад явсан. Сумын Эрүүл мэндийн төвөөс “Шинэ эм-эмийн сонголт”, “Миний гэр аюулгүй орчин”, “Хеликобактер-элэгний В, С” вирусын халдварын сургалт зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 90 гаруй иргэд хамрагдав.

Үенч сум: Сумын Засаг даргын 2018 оны А/11 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан сумын удирдах ажилтнуудын зөвлөгөөн зохион байгуулж энэ үеэр 2017 онд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж 2018 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулав. Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг сумын нийт ард иргэдэд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны 2017 оны хэрэгжилтийн биелэлт танилцуулж цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч иргэдийн санал бодлыг сонсож тэдний сонирхсон асуултад хариулт өгөв.

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу арьс шир бэлтгэн үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин мал бүхий этгээдийн арьс ширний падааныг итгэмжлэгдсэн төлөөлөгчийн цахим системд шивж материалыг ХХААГазарт хүргүүлж ажилласан ба арьс ширний урамшуулалд 327 өрхийн 491 баримт тушаасан. Үүнд адууны шир 15, үхрийн шир 395, хонь 1401, ямааны арьс 3158 бүгд 4969 арьс шир хүлээлгэн өгөв.

Чандмань сум: Тус сумын Засаг даргын Тамгын газар аппаратын өргөтгөсөн хурал зохион байгуулж ажилтан, албан хаагчид үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээг байгуулж байгууллагын 2018 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг баталлаа.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд Засаг дарга 12 өргөдөл бичгээр хүлээн авч, 5 өргөдлийг шийдвэрлэж, 7 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Орон нутгийн хэмжээнд цаг агаар эрс хүйтэрч цас их унасаны улмаас малчдын өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан хөдөөгийн багийн малчдын цаг үеийн нөхцөл байдлыг газар дээр нь судлах, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор 4 ажлын хэсэг байгуулагдан малчдын санал хүсэлтийг сонсож цаг үеийн байдалтай танилцаж 500 гаруй өрхөөр орж, өвс, тэжээлийн хөнгөлөлт, эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэн ажиллаа.

Сум орон нутагт спортын хөгжлийг эрчимжүүлэх, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, идэвхитэй дасгал хөдөлгөөнийг дэмжих, иргэдийн дунд соёл урлаг, спортын арга хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 2018 оны 01 дүгээр сарын 20-21-ны өдрүүдэд сумын Засаг даргын нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж 190 гаруй иргэдийг хамруулав.

2018 оны 01 дугаар сард иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд шинээр төрсөн хүүхэд 8, гэрлэлт 2, шилжин явсан 4, шилжин ирсэн 2, 25, 45 насны иргэдийн паспортын сунгалт 13, шинээр паспорт 2 иргэн, хаяж гээгдүүлсэн 2 иргэний хүсэлтийг тус тус хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэлээ.

Сумын төсвийн орлогод 2560,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс урьдчилсан байдлаар 2051,1 мянган төгрөг төвлөрч 80,1 хувийн гүйцэтгэлтэй байна. 2017 оны жилийн эцсийн татварын бүх төрлийн 83 тайланг аж ахуйн нэгж, төсөвт албан байгууллага, банкны салбаруудаас хүлээн авахаас 44 тайланг хүлээн авч 53 хувьтай байна. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдсан 35 татвар төлөгчийн 10939,4 мянган төгрөгийн буцаан олголтын тайланг хүлээн аваад байна.

Сумын хэмжээгд 2017 оны жилийн эцэст 254717 толгой мал тоологдсон ба энэ нь хонин толгойд шилжүүлбэл 361447,2 хонь болж 530 малчин өрхтэй байна. 2017 онд зуншлага муу гандуу, хуурайшилт ихтэй байсны улмаас нийт нутгийн 90 гаруй хувьд малын өвөлжилт хаваржилт нэн хүндрэх төлөвтэй болсны улмаас нийт малын 40 гаруй хувь нь отроор нүүдэл хийж, 74 өрх 263 хүн, 45542 толгой мал, 111 өрхийн 48820 толгой мал тавиулаар нийт 100038 толгой мал өвөлжиж байгаа дүн мэдээтэй байна. Өдөр бүр цас будран орж цасны зузаан аажмаар нэмэгдэж 5 см жалга гуундаа 40-50 см болж хүйтний эрч чангарч мал хотноос гарч идээшлэх нөхцөл боломж улам хомсдон мал дарагдаж, турж эцэн хорогдол нэмэгдсээр байна. Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2018 оны 06-07-ний өдрүүдэд тус суманд ажиллаж цаашид авах арга хэмжээний талаар ярилцан санал хүсэлтийг хүлээн авч ажиллав.

Сумын Засаг даргын захирамжаар 4 ажлын хэсэг томилогдон нийт 6 багийн малчин иргэдтэй уулзаж өвөлжилтийн байдалд дүгнэлт хийхийн зэрэгцээ сумын аюулгүйн нөөц фондны 424 уут тэжээл 500ш пресс өвс Засгийн газрын хөнгөлөлтөөр олгож буй 550 уут хорголжин тэжээлийг баг бүрт хуваарилан олгов.

Сумын хэмжээнд тэмээ 89, адуу 404, үхэр 747, хонь 3416 ямаа 5471 бүгд 10127 толгой мал хорогдсон ба үүнээс ингэ 4, гүү 45, үнээ 121, ямаа 261 бүгд 431 хээлтэгч мал хорогдсон дүн мэдээтэй байна. Энэ сарын сүүлийн 10 хоног хүйтэн цас орох төлөвтэй цасан бүрхүүл улам нэмэгдэж мал маллагаанд хүндрэл учирч өвөлжилт хүндрэх төлөвтэй байна.

Монгол улсын Засгийн газрын 122 дугаар тогтоолоор малчин, мал бүхий этгээдийн арьс ширний баримтыг шивж 350 ширхэг баримтыг 6139 арьс шир бүртгэв.

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд амьжиргааг дэмжих зөвлөл 1 удаа хуралдаж хуулийн дагуу нийт 72 иргэнд 10080.0 мянган төгрөгийн халамжийн тэтгэвэр, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмж нийт 67 иргэнд 4288.0 мянган төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмж 28 иргэнд 1120.0 мянган төгрөгийг тус тус олгов. Мөн цалинтай ээж хөтөлбөрт 148 иргэн, насны хишиг авах 106 ахмад настан, 1 дүгээр одонгийн мөнгө авах 126 иргэн, 2 дугаар одонгийн мөнгө авах 215 иргэний материалыг хүлээн авч тэтгэмжүүдийг олгохоор бэлтгэл ажил хийгдэж байна.

Сумын Эрүүл мэндийн төв нийт 39 амбулаторийн үзлэг хийж, 34 иргэн, 5 хүүхэд үйлчлүүлсэн. Эрүүл мэндийн төвийн ажилчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, 2018 онд хийх байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөг батлуулав.

Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлага, мэдээллийг бэлтгэн хорьт болон хөдөөгийн багийн өрхөөр тарааж нийт 500 гаруй өрхийн иргэдэд мэдээлэл өгч урьдчилан сэргийлж ажилласан.

Дуут сум: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ээлжит хуралдаан 2 удаа хуралдаж 3 асуудал хэлэлцэн 2 тогтоол гаргав. Сумын ИТХ-ын төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга нийт 15 хүн 2018 оны 01 дүгээр сарын 06-12-ны өдрүүдэд Чингэлтэй дүүргийн ИТХ-ын ажлын албаны зохион байгуулалт, ажиллах журам, хурлын хуралдааны бүтэц болон иргэний танхимын үйл ажиллагаатай танилцаж туршлага судлав.

Сумын хэмжээнд цас үргэлжлэн орсноор өвөлжилтийн байдал хүндэрч үүнтэй холбогдуулан сумын ЗДТГ-аас өвс худалдан авах гэрээг Буянт сумын иргэдтэй хийж 350 боодол өвсийг малчдын гар дээрээс худалдан авсан. Аймгийн аюулгүйн нөөцөөс 600 боодол өвс, 200 уут тэжээл өгсөнийг хүлээн авч малчдад хуваарилалтаар олгов.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу 01 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд урианхай уртын дууны наадмыг амжилттай зохион байгуулж, эхний 3-н байрын шагналыг тус сумаас соггогдсон аймгийн ИТХ-ын төлөөлөгч Ч.Чинбат 4,200,000 төгрөгөөр санхүүжүүлж шагналын эзэнд гардуулан өгөв.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт үнэлгээний ажлын хэсгийн өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж сургуулийн багш, ажилтнуудын хувийн хэрэгт баяжилт хийж, ажилтнуудын хөдөлмөрийн гэрээ, байгууллагын ёс зүйн хороог шинэчлэн байгуулав

“Хуулиа мөрдөө-21” аяны хүрээнд архины хор хөнөөлийг сурталчлан таниулах сургалт үйл ажиллагааг сургуулийн багш, ажилчид, сурагчдын дунд зохион байгуулав.

Сумын Эрүүл мэндийн төвд 32 иргэн хэвтэн эмчлүүлсэн ба алсын дуудлагад 25 удаа явж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэв.

Сумын Ерөнхий боловсролын сургууль байгууллагын 2018 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа аймаг, сумын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулж боловсрууллаа.

“Хүүхэд бүр цэцэрлэгт”, “Номын гэгээ”, “Авъяас”, “Чадварлаг багш”, “Боловсрол” хөтөлбөрүүдийн хүрээнд хийх ажил, зохион байгуулах уралдаан тэмцээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан ажиллав.

Ханиад томууны дэгдэлт их хүүхдийн өвчлөлөөс шалтгаалан цэцэрлэгт ирж байгаа хүүхдийн тоо эрс буурснаас Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яамны сайдын 2018 оны А/007, А/14 тоот тушаалаар сургалтын үйл ажиллагааг 14 хоногийн хугацаанд хаасан, цаг агаар хүйтэрч, сумын онцгой комисс бэлэн байдал зарлаж албан байгууллагуудын халаалт дулаан, хэвийн үйл ажиллагааг хянах жижүүр гаргасан үеэр хариуцлагатай жижүүр ажиллуулах хуваарийг бүх багш ажилтнуудыг оролцуулан гаргаж байгууллагын өдрийн үйл ажиллагаа болон оройн цагаар эргүүл

хийх шаардлагатай тохиолдолд удирдлагад цаг алдалгүй мэдээлэх ажлыг зохион байгууллаа.

Байгууллагын санхүүгийн өмнөх оны мэдээллийг шилэн дансанд шивж илгээ холбогдох байгууллагад илгээв. Мөн байгууллагын 2018 оны төсвийн сарын хуваарийг хийж дээд шатны байгууллагад саналаа хүргүүлэв.

Сумын урианхай сурын холбооноос сурын нээлтийн харвааг 01 дүгээр сарын 6-7-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 25 харваач оролцов. Мөн оюутан, залуучуудын дунд спорт, урлагийн наадам зохион байгуулсан ба тус наадамд спортын 2 төрөлд 30 гаруй залуучууд оролцов.

Дөргөн сум: Сумын удирдлагаар ахлуулсан 4 ажлын хэсэг бүх багийн айл өрхөөр орж, өвөлжилтийн нөхцөл байдлын явцтай биечлэн танилцаж учирч буй хүндрэл бэрхшээл, даван туулах арга зам, өвс тэжээлийн захиалгын талаар иргэдтэй ярилцаж, цаг үеийн мэдээлэл өгч, эмнэлэгийн тусламж үйлчилгээг газар дээр нь хүргэж ажиллалаа. Энэ үеэр малчид өвөлжилтийн байдал хүндрэх шинжтэй хүйтний эрч чангарч цас ихээр орвол хэвтэр бууц хөлдөж, мал өөдөх, хөлдөх, харз ус руу орох зэрэг хүндрэлүүд тулгарч байгаа талаар ярьж тэдний санл бодлыг сонсов.

Аймгийн ХШҮДА-ын хэлстийн даргаар ажлын хэсэг сумын ЗДТГ, төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт хийж Засгийн газрын тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны үндсэн чиглэлийн биелэлт, аймгийн Засаг даргатай сумын Засаг даргын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, гэрээний хэрэгжилт, аймаг, сумын ИТХ-ын тогтоол шийдвэр, байгууллагуудын хөгжлийн стратеги төлөвлөгөө, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт, ёс зүйн хорооны ажил, сум хөгжүүлэх болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, зээл эргэн төлөлт зэрэг ажлуудын биелэлт, үр дүнг шалгаж үнэлэлт өгөв.

Цэргийн тоо бүртгэлийг хугацаанд нь явуулж тайлан мэдээг цэргийн штабт хүргүүлж ажиллалаа. Төсөвт байгууллагын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, эрх бүхий албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэгийг программд шивж баталгаажуулсан

Дэлхийн зөн Олон улсын байгууллагын хөтөлбөрийн чиглүүлэгчээр ахлуулсан ажлын хэсэг сумын Засаг дарга болон албан байгууллагуудын дарга эрхлэгч, нийгмийн ажилтан нарын дунд төсөл хөтөлбөрийг танилцуулах сургалтыг зохион байгуулж, цаашид хамтран ажиллах төслүүдийн талаар ойлголт мэдээлэл өглөө. 2018 оны 01 дүгээр сараас эхлэн зорилтот бүлгийн өрхийн амьжиргааг дээшлүүлэх “Төгсөлтийн аргачлал” сэдэвт төслийг суманд хэрэгжүүлэхээр болж, сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдан баг тус бүрээс 4-5 өрх, нийт амьжиргааны доогуур түвшний 15 өрхийг сонгон авч, төслийг хэрэгжүүлэхээр хяналт үнэлгээ, судалгааны шатандаа хүлээгдэж байна.

Сумын сайн малчин шалгаруулах журам боловсруулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, журмын дагуу сумын сайн малчнаар 22 малчинг шалгарууллаа.

Хонь тэмээний ноосны урамшуулалд 28,9 тн тэжээлийн захиалга авч холбогдох байгууллагад хүргүүлэв. Мөн аймгийн нөөцийн газраас 475 ширхэг өвс, 200ш тэжээл татан авч малчдад олгоод байна.

Малчдаас малын хорогдлын мэдээг авч нэгтгэн аймгийн ХХАА-н газар болон Онцгой байдлын газарт хүргүүлж байна.

Мерсикор ОУБ-ын төлөөлөгчид болон аймгийн төслийн зохицуулагч багийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 01 сарын 16-нд ажиллаж сумын удирдлагууд, багийн Засаг дарга, байгууллагын дарга эрхлэгч, мал эмнэлэгийн мэргэжилтэнүүдтэй уулзалт хийж төслийн хэрэгжилтийн тухай мэдээллийг сонсож Агваш-арал” МЭҮН-ийн ажлын байртай танилцаж, 3 малчин өрхөөр орж тэдний санал бодлыг сонсов.

Аргалант багийн “Хөх эргийн аараг”-т нөхөн сэргээлт хийж байгаа “Блю голд “ХХК-ны нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөний хугацаа дууссантай холбогдуулан 01 дүгээр сарын 08-ны өдөр аймгийн БОАЖГ, МХГ, УТХГНХЗ-ны хамтарсан ажлын хэсэг цаашид хийх нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөг нэмж батлуулах, хугацаанд нь дуусгах талаар шаардлага тавьж машин техникийг лацдаж, үйл ажиллагааг нь түр зогсоолоо

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, ТХГН-ын тухай хууль, Амьтны тухай хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангах зорилгоор “Хяналт шалгалт хийх” мэргэжлийн байгууллагын ажлын хэсэг томилогдон удирдамж батлуулж, 2 чиглэлийн маршрутаар хяналт хийж ажиллав. Дөргөн сумаас Аргалантын уул, Модон улаан, Шарга морьт, Тээлийн хар хүртэл 160 км, Хар нуураас Багалзуур, Бургастай, Хорт шанаа хүртэл 60 км, нийт 220 км газрыг туулж, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв. Хяналтын явцад Аргалант ууланд өвөлжиж буй цөөн тооны янгирт биотехникийн арга хэмжээ авч, Хар нууранд хууль бус загас агнахаар тавьсан эзэн холбогдогч нь тодорхойгүй 10 ширхэг торыг хурааж, загаснуудыг нь усанд буцаан тавьж зөрчлийг арилгаж ажилласан.

БОАЖЯ-ны хяналт шинжилгээ, үнэлгээ аудитын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг сумын Усан цахилгаан станц болон Хөх эргийн аарагт нөхөн сэргээлт хийж байгаа Блю голд ХХК-ны үйл ажиллагаатай танилцаж, нутгийн иргэд, компаний ажилчидтай уулзаж, цаашид авах арга хэмжээний талаар санал бодлоо солилцон заавар чиглэл өглөө.

Шинээр газар өмчлөх хүсэлт ирүүлсэн иргэдийн хүсэлтээр “Босоо тэнхлэг нөхөрлөл” ХХК-аар 7 айлд кадастрын зураг хийлгүүлэв. 10 иргэний газар өмчлөх тухай өргөдөл хүсэлтийг хүлээн авч, хуулийн хугацаанд нь шийдвэрлэхээр холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн ажиллаж байна.

2018 оны тайлант сард нийтдээ 348 тэтгэвэр авагчдад 90082,3 төгрөгийн санхүүжилтээр тэтгэвэр олгосон ба 2 иргэнд өндөр насны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоох эрх үүсгэв. Сайн дурын даатгалд 26 даатгуулагчийн 1819,8

төгрөг, төсвийн байгууллага болон ААН-ийн 473,0 мянган төгрөгийн шимтгэлийн орлого тус тус төвлөрүүлсэн. Эрүүл мэндийн даатгалд 40 хүний 1039,2 мянган төгрөгийн орлого оруулав. Тэтгэмжийн сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан 1 даатгуулагчид 590,6 төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 5 даатгуулагчид 3797,8 мянган төгрөгийг тус тус олгов.

Ахмадын насны хишгийг 65-69 насны 30 ахмадад 1,500,000 төгрөг, 70-79 насны 50 ахмадад 4,000,000 төгрөг, 80-89 насны 7 ахмадад 1,050,00 төгрөгийг тус тус олгоод байна. Цалинтай ээж тэтгэмжийг 154 эхэд, алдарт эхийн 1 дүгээр одонгийн тэтгэмжийг 120 эхэд, 2 дугаар одонгийн тэтгэмжийг 217 эхэд тус тус олгов.

Нийгмийн халамжийн сангаас ахмад настны асаргааг 64 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргааг 20 хүн, жирэмсний тэтгэмжийг 25 эх, халамжийн тэтгэвэрийг 42 хүнд, халамжийн тэтгэмжийг 9 хүүхдэд, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 14 хүнд тус тус олгоод байна. Гурав ба түүнээс дээш 0-18 насны хүүхэдтэй өрх толгойлсон 7 эцэг эхэд улиралд 240000 төгрөг олгосон.

Сумын ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн 41 сурагчдад хэсгийн төлөөлөгч, сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтан нар хамтарч “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар цахим орчны хэрэглээ, насанд хүрээгүй хүүхэд тээврийн хэрэгсэл жолоодох ба түүний эрсдэл шөнө оройн цагаар дэмий сэлгүүцэх, архи тамхины хэрэглээ зэрэг хүүхдийн орчинд үүсэх хэргийн талаар мэдээлэл өгч, эдгээр гэмт хэргээс сурагчид өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвартай болох талаар мэдээлэл өглөө.

Элсэлтийн ерөнхий шалгалтанд төгсөх ангийн сурагчдыг амжилтай оролцуулахын тул эцэг эхчүүдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор эцэг эх, багш, сургуулийн захиралтай гуравласан гэрээ байгуулсаны дагуу 12 дугаар ангийн сурагчдын эцэг эхийн хурлыг зохион байгууллаа. Хурлаар 14 хоног болгон авдаг ЭЕШ-ын сорилын дүнг танилцуулж, цаашид улам сайжруулах талаар санал бодлоо солилцож, сургууль болон гэрийн нөхцөлд хичээлээ давтах боломжийг олгоход эцэг эхийн анхаарал чухал байгаа талаар сургуулийн удирдлагууд ярилаа.

Сургуулийн ажилчдын хурал зохион байгуулж, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, сургуулийн дотоод журам, байгууллагын стратеги төлөвлөгөө, 2017-2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг, ёс зүйн дүрмийг хэлэлцэн шинэчлэн батлав.

Сумын Эрүүл мэндийн төв аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газартай хамтран сумын өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 0-5 насны хүүхэд, жирэмсэн эх, эмзэг бүлгийн гишүүнтэй 30 айл өрхөөр орж, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үзлэг оношлогоо болон шаардлагатай эмийн үйлчилгээ үзүүллээ.

Умайн хүзүүний хавдарын эрт илрүүлэг шинжилгээнд 30-60 насны 9 иргэнийг хамруулав.

Сумын хүүхдийн цэцэрлэг хүүхдийн сурч хөгжих аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран анги танхимуудад

ариутгал халдваргүйжилт хийж, цэцэрлэгийн гадна орчинд хальтиргаа гулгаа үүсгэж байгаа цасыг цэвэрлэж, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаа.

Буянт сум: Тус сумын Засаг даргын Тамгын газар иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх чиглэлээр дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тайлант сард иргэдээс бичгээр 67 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн ба иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээг нийт 322 иргэнд үзүүллээ.

Сумын Эрүүл мэндийн төв тайлант сард нийт 421 иргэнд үзлэг хийж, үүнээс урьдчилсан сэргийлэх үзлэгийг 102, өвчний учир амбулаториор 229, гэрийн идэвхитэй эргэлт 18, идэвхитэй хяналтаар 37 удаа явж эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэв. Нийт 47 өвчтөн хэвтэн эмчлүүлж, алсын дуудлагад 35 удаа явж жирэмсний хяналтанд шинээр 6 эхийг хяналтанд авч, 3 сартай хүүхдүүдийг зохих шинжилгээнд хамруулж хянан ажиллаж байна. Товлолын дагуу нийт 31 хүүхдэд хөдөө багуудаар явж дархлаажуулалтанд хамрууллаа.

2017 онд жилийн ажлын тайланг Эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтнүүдэд тайлагнаж ажиллалаа.

Засгийн газраас баталсан Монгол улсын боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг орон нутгийн боловсролын байгууллагын үндсэн чиглэл үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажилласан ба байгууллагын дотоод журам, цэцэрлэгийн ариун цэвэр аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолтыг шинээр баталж, багш ажилчдад “Ажлын байрандаа хөгжих нь” “Багшийн ёс зүй” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

“Авъяас” хөтөлбөрийн хүрээнд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх тэдний авъяас чадварыг нээн илрүүлэх зорилгоор 5 төрлийн дугуйлан хичээллүүлж цэцэрлэгийн хүүхдийг бүрэн хамруулсан.

2017 оны жилийн эцсээр суманд нийт 215823 мал тоологдсон, цасны зузаан 5-15 см, малын зүй бус хоргодол 1265, үүнээс адуу 6, үхэр 26, хонь 252, ямаа 981, сумын өвсний аюулгүйн нөөцөд 6868 тонн өвс тэжээл бэлтгэгдсэн ба үүнээс 4494 тонныг зарцуулаад байна.

Сумын хэмжээнд 3 иргэнд холбогдох хуулийн дагуу эрх зүйн зөвлөгөө өгч, хэсгийн төлөөлөгч болон цагдаа хэв журам сахиулахаар шөнийн эргүүлийг 18 удаа 129 цаг гарч, ахуйн дуудлагад 2 удаа, биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон 1 иргэнийг түр саатуулан ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажиллаа. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг хүнсний дэлгүүрүүдэд давхардсан тоогоор 19 удаа хяналт шалгалт хийв.

Булган сум: Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг мус суманд ажиллаж аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилт болон нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, бүтээн байгуулалтын ажлуудын талаар тайлан тавьж иргэд хөдөлмөрчдийн сонирхсон асуултанд хариулт өгч ажиллав.

Сумын Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн амбулаторийн хүүхдийн тасгаар 0-16 насны 211 хүүхэд, дотрын тасгаар 858 иргэн, эмэгтэйчүүдийн тасгаар 176, мэс заслын тасгаар 158 иргэн үйлчлүүлсэн ба 76 өвчтөн хэвтэн эмчлүүлэв.

Багуудын Иргэдийн нийтийн хурал хуралдаж багийн Засаг дарга нарын 2017 онд хийсэн ажлын тайланг хэлэлцэж, цаг үеийн асуудлаар иргэдэд мэдээлэл өгч ажиллав.

“Хуулиа мөрдье 21” аяны хүрээнд сумын хэмжээнд архи согтууруулах ундаагаар үйлчилдэг дэлгүүр, үйлчилгээний газруудад хяналт хийж, 18-аас доош насны хүүхдүүдэд архи худалдаалахгүй байх, архины худалдаа хийлгэхгүй байх талаар зөвлөмж өгч ахлах ангийн сурагчдын дунд Архины хор нөлөө, хорт зуршлын талаар сургалтыг сумын нийгмийн ажилтан, Цагдаагийн хэлтсийн хэв журмын байцаагч, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нар хамтран зохион байгууллаа.

Эрдэнэбүрэн сум: Сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын 2017 оны хийсэн ажлын тайлан хэлэлцэж сумын удирдлагууд үнэлгээ өглөө.

Багийн Иргэдийн нийтийн хурлаар багийн Засаг дарга нарын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн тайлан, багийн хүний эмч, малын эмч нарын 2017 оны ажлын тайланг хэлэлцэж иргэдийн оролцоогоор үнэлгээ өгч ажиллав.

Сумын хэмжээнд 2018 онд зохион байгуулагдах нэгдсэн арга хэмжээ, нийтийг хамарсан ажлын календарчилсан төлөвлөгөөг гаргаж бүх төрийн байгууллагуудын мэдээллийн самбарт байрлуулж, тус төлөвлөгөөний дагуу ажлаа төлөвлөх уялдуулж хамтран ажиллах боломж бүрдүүлэв. Тус төлөвлөгөөнд нийт 44 ажил тусгагдсан.

Сумын Эрүүл мэндийн төвөөс төсөвт байгууллагууд, ард иргэдийг хамруулсан “Эрүүл агаар-эм” сэдэвт явган аялал, цас мөсний баярыг зохион байгуулсан ба тус арга хэмжээнд 60 гаруй хүн оролцлоо.

Цэргийн бэлтгэл үүрэгтэн, бэлтгэл офицеруудын 2018 оны тоо бүртгэлээр 608 бэлтгэл үүрэгтний бүртгэл хийж аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабт хүргүүллээ.

Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөөс 600ш пресс өвс, 200 уут хивгэн тэжээлийг татаж шаардлагатай малчдад хүргүүлж ажиллав.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу сумын нийт 33 төрийн албан хаагчид, ИТХ-ын төлөөлөгчдийн ХАСХОМ-ыг нэгтгэн гаргаж программд шивж баталгаажилт хийлээ.

Сумын байгаль орчны албанаас биотехникийн аргаар Хавцлын амны янгир ямааны усанд ордог газруудад өвс тавьж, шинэ арал, шаазгай арал, шар арлуудаар холбогдох албан тушаалтан байгаль орчны хяналт хийж ажиллав.

“Аймгийн аварга малчин”-аар шагнагдах болзол хангасан Намарзан багийн мянгат малчин, сумын аварга малчин О.Бямбадорж, Хонгио багийн малчин, сумын аварга малчин Л.Отгонбаяр, Шураг багийн малчин, сумын аварга малчин Цо.Эрхэмбаяр, Баянгол багийн малчин, аймгийн аварга малчин Я.Өлгийсайханыг

“Аймгийн хошой аварга малчин”-аар шагнуулахаар материалыг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газарт уламжлав.

Сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаар “Сумын аварга малчин”-аар шагнах 32 малчныг журмын хүрээнд хэлэлцэн шалгарууллаа.

“Малчдадаа тусалъя” сайн санааны аяныг сумандаа амжилттай зохион байгуулж нийт иргэддээ “Уриалга” гаргаж ажилласнаар 8 байгууллага, 5 аж ахуйн нэгж, 2 иргэнээс 700000 төгрөг, 27 уут тэжээл, 13 төрлийн хувцас, ахуйн хэрэглээний зүйл, 4 төрлийн тэжээлийн бүтээгдэхүүн цугларсан.

Монгол улсын Засгийн газрын 122 дугаар тогтоолын дагуу 2015 оны арьс, шир бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий иргэдийн 963 баримтыг программд шивж холбогдох байгууллагад хүргүүлээ.

Мөнххайрхан сум: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 2 удаа хуралдаж, ИТХ-ын орон тоо, цалингийн сан батлах тухай, өмч хөрөнгийг акталж данснаас хасах тухай, хөрөнгө шинээр орлого авахыг зөвшөөрөх тухай, ИТХ-ын 2017 оны санхүүгийн тайлан, ИТХ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай, багийн ИНХ-ын 2017 оны үйл ажиллагааг үнэлж дүгнэх тухай, зарим хүмүүсийг төрийн дээд шагналд тодорхойлох тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв

Сумын хэмжээнд үргэлжлэн орсон цасны нөлөөгөөр нийт нутаг дэвсгэрт цасан бүрхүүл тогтож, улмаар хүйтний эрч эрс чангарснаас үүдэлтэй мал аж ахуйд хүндрэл учирч, малчид зудын байдалд орсонтой холбогдуулан сумын Засаг даргын захирамжийн дагуу 4 ажлын хэсэг байгуулагдан 2018 оны 01 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд 4 багт ажиллаж, ажлын тайлан мэдээг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллалаа.

Сумын Засаг даргын зөвлөлийн хурлыг 2018 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 09 цагт зарлан хуралдуулж, албан байгууллагын дарга эрхлэгч нартай 2018 оны үр дүнгийн гэрээ байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, 2018 оны хөрөнгө оруулалтын санал авах, төсөл боловсруулах ажлын чиглэл өгч, Монголын цагаан сарыг угтаж, бүх нийтийн цэвэрлэгээ хийх, ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, “Малчиддаа туслая” аяны хэрэгжилтийн талаар болон байгууллагын үйл ажиллагааны талаар малчдын зөвлөгөөнд байгууллага бүр мэдээлэл хийх зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Сумын Засаг даргаар батлуулсан удирдамж, хөтөлбөрийн дагуу 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр малчдын зөвлөгөөн зохион байгуулж, зөвлөгөөнд аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг малчид, ард иргэдтэй уулзаж, цаг үеийн нөхцөл байдал малчдын ажил маьдралтай газар дээр нь танилцаж ажиллалаа. Зөвлөгөөний үеэр “Малчиддаа туслая” сайн санааны хандивын аяны хүрээнд цугларсан эд зүйлийг малчдад гардуулан өглөө.

Аймгийн онцгой комиссын шийдвэрээр өвөлжилт хүндэрч байгаа сумдад тус бүр 600 боодол өвс, 150 уут тэжээл хуваарилсныг орон нутагт татан авч малчдад 1 боодол өвс, 1 уут тэжээл малчдад хуваарилж хүргүүлэв. Өвс тэжээл нийлүүлэх

тендерт шалгарсан “Жинст транс” ХХК, “Бадрангуй” ХХК-иудад малчид авах өвс, тэжээлийн захиалгыг авч нэгтгэн хүргүүлэв.

Монгол улсын ЗГ-ын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу үндэсний үйлдвэрт тушаасан арьс ширний урамшууллын баримт бүрдүүлж, цахим санд нэг бүрчлэн оруулж, тайлан мэдээг тушаав. Сум орон нутгаас бэлтгэсэн 307 өрхийн 8600 гаруй арьс шир үндэсний үйлдвэрт бэлтгэн нийлүүлсэн.

Үдийн цай хөтөлбөр, хүнс худалдаалдаг, үйлчилдэг цэгүүдэд өдөр тутмын хяналтыг тавьж, мэдээллийн дагуу хяналт шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллаж байна.

Өвөлжилт хүндэрч цас унаж, бууц хөлдөн малын хоол тэжээл хомсдож, малчид эрт хаваржаандаа гарч, малын хээл хаяж, хорогдох болсонтой холбогдуулан 2017 оны 12 дугаар сарын 31-нээс 2018 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хүртэл үргэлжлэн орсон цасны зузаан 5-8 см, хунгарласан газраа 15-17 см зузаан, хүйтэрсэнтэй холбоотой ханиад томуу дэлгэрч, цусны даралт ихсэх зэрэг хүндрэлүүд гарч, хөдөөд ажилласан ажлын хэсэг цогц үйлчилгээ үзүүлэн малын хорогдлын мэдээ, хээл хаялтын мэдээ авч, 7 хоног бүр аймгийн ХХАА-н газарт хүргүүлэн ажиллаж байна.

Малын хорогдол Алаг багт-368, Борт багт-439, Хаг багт 155, Сэнхэр багт-378, сумын дүнгээр 1335 толгой мал хорогдож, 89 толгой мал хээл хаясан дүнтэй байна.

БОАЖЯ-аас биотехникийн арга хэмжээнд зориулж 4100,0 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлснийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас цаг үе хүндэрсэнтэй холбоотойгоор зэрлэг амьтдад биотехникийн зориулалтаар хувиарлагдсан 100ш пресс өвс, 300 кг давсыг хүлээн авч 2018 оны 1 сарын 25-ны өдрөөс эхлэн Мөнххайханы БЦГ-ын ХЗ-ны байгаль хамгаалагч, сумын байгаль хамгаалагчид аргаль, янгир, буга зэрэг зэрлэг амьтдын байршил бүс нутагт биотехникийн арга хэмжээ авахаар төлөвлөгөө, зураглал гарган ажилласан төдийгүй Борт багийн Хар давд 8ш пресс өвсийг янгирын бэлчээрт гарган тавьж биотехникийн арга хэмжээ авсан.

Газар эзэмших, газрын хэмжээ талбай өөрчлүүлэх, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ шинээр авах тухай 27 өргөдөл хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн ба үл хөдлөх хөрөнгийн хэмжээ талбай өөрчлөх тухай 2 захирамж гаргаж, гэрчилгээ гаргуулан байшингийн үл хөдлөх авахаар материалыг бүрдүүлэн Улсын бүртгэлийн газарт хүргүүлж гэрчилгээ гаргуулав.

Газар эзэмших эрхийн гэрээ дүгнэж, зөрчил арилгах тухай удирдамж боловсруулан, удирдамжийн дагуу газар эзэмших бүртгэлд хяналт хийсэн мөн нас барсан, Ховд, УБ хот шилжээд олон жил болсон ч газар эзэмших эрхээ шилжүүлээгүй, газраа өөрөө эзэмшэхгүй хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтаар ашиглаагүй, газрын төлбөрөө хугацаандаа төлөөгүй зэрэг шалтгаанаар 69 нэгж талбарын газар эзэмших эрхийг сумын Засаг даргын 2018 оны А/04 дүгээр захирамжаар хүчингүй болгож холбогдох иргэдэд мэдэгдэх хуудас хүргүүлэв.

Олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг хүрээнд 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч буй 89 эх, жирэмсэн эхийн тэтгэмжид 8 эх, өрх толгойлсон эх, эцэгт 3 иргэний материал хүлээн авч Wais програмд шивэлт хийлээ. Өвчний учир байнгын асаргаа шаардлагатай байгаа 3 иргэн асаргаанд хамрагдаж, асаргааны хугацаа дуусаж буй 20 иргэний сунгалтыг сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэв. Сэнхэр багийн иргэнийг өөрийн хүсэлтээр аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн сэргээх төвд асруулахаар зөвлөл шийдвэрлэлээ.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний судалгааг шинэчлэн гаргаж, харьяалалгүй ахмадын судалгааг ХХҮГ-т хүргүүлэв.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй 13 өрхөд "Их хунт" аж ахуй нэгжээр 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг олголоо.

Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авч буй иргэдийн 1 дүгээр сарын санхүүжилтийн эрх нээв олгов.

Сумын Эрүүл мэндийн төв 60 иргэн хэвтэн эмчлүүлсэн ба алсын дуудлагад 21 удаа явж эмийн бус эмчилгээгээр 59 хүнд үйлчилсэн. Урьдчилан сэргийлэх зорилгоор товллын дархлаажуулалтанд 0-2 насны 23 хүүхдийг 100 хувь хамруулж, "Элэг бүтэн-Монгол" үндэсний хөтөлбөрийг 2018 онд 15-39 нас, 65-аас дээш насны зорилтот хүн амд элэгний В, С вирусын шинжилгээнд хамруулахаар судалгааг гаргаад байна.

2018 онд "Хүнээ хөгжүүлэе, эерэг, хандлага, мэргэжлийн ёс зүйг эрхэмлэх" зорилт дэвшүүлж, байгууллагын дотоод журмаа шинэчлэн мэргэшүүлэх болон мэргэжлийн сургалтын хуваарийг хэлэлцэн баталлаа.

Аймгийн Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн ажилтан, хүүхдийн эмч, мэдрэлийн эмчийн бүрэлдэхүүнтэй баг ажиллаж, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хийж тусламжийн эм тараах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч, нийт 51 хүн үзэж, 30 өрхөд тусламжийн эм тараав.

Сумын Ерөнхий боловсролын сургууль хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, Цагаан сарын өглөөлөг, Чадварлаг Ховдчууд наадмын бэлтгэл ажлыг хангахын зэрэгцээ хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх ардын уламжлалт тоглоом наадгайгаар хичээл заасан. Хувилбарт сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж багш хүүхдийн судалгаанд үндэслэн хөтөлбөрөө боловсруулж бэлтгэл хийв.

Хамран сургах тойргийн 2-5 настай хүүхдийн болон цэцэрлэгт хамрагдаагүй хувилбарт сургалтанд хамрагдах хүүхдийн судалгаа гаргасан.

Соёлын төвөөс долоо хоног бүрийн 3 дахь өдөр нийтийн бүжгийн дугуйлан хичээллүүлж 5 төрлийн бүжиг зааж давхардсан тоогоор 63 хүн хамрагдав.

2017 оны орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг жилийн эцсийн байдлаар нэр төрлөөр нь гаргаж аймгийн төрийн сангийн хэлтэст цаасаар буюу цахимаар хүргүүллээ. Орлогын төлөвлөгөөгөөр 32080.0 мянган төгрөг орохоос 41132.1 мянган төгрөг орж 9052.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн. Орон нутгийн орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь гаргаж үзэхэд ус, рашаан ашигласны төлбөр 55 хувиар,

хүү торгуулийн орлого 39.6 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 47.1 хувиар, үйл ажиллагааны орлого 15.8 хувиар биелсэн ба бусад нэр төрлийн орлого бүрэн биелэснээр жилийн орлогын төлөвлөгөө 9052.1 мянган төгрөгөөр давсан буюу 128.2 хувиар биелсэн.

Сумын нийт төсөвт байгууллагуудын төсвийн зарцуулалтын мэдээг салбараар буюу орон нутгийн байгууллагуудаар нэгтгэл хийж аймгийн төрийн сангийн хэлтэст цаасаар буюу цахимаар хүргүүлэв.

2018 онд орон нутгийн хөгжлийн сан буюу орон нутгийн хөрөнгө оруулалтын сангийн эх үүсвэрээр хийгдэх төсөл, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийн худалдан авалтын төлөвлөгөө боловсруулан аймгийн орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны мэргэжилтэнд хүргүүлж, Засгийн газрын худалдан авах ажиллагааны “tender.gov.mn” сайтад шивж баталгаажуулав.

Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсээс орон нутгийн дундын сүлжээнд байршуулсан мэдээллээс бүх төсөвт байгууллагуудын санхүүжилтийг татан авч сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодогчтой тулгалт хийж санхүүгийн тайлан гаргах бэлтгэл хангалаа. Мөн орон нутгийн дундын сүлжээнд байршуулсан 2017 оны санхүүгийн тайлан гаргахтай холбоотой мэдээллүүдийг татан авч нягтлан бодогчдыг мэдээллээр хангав.

Байгууллагуудын 2018 оны төсвийн сар улирлын хуваарь хийж холбогдох мэргэжилтэнгүүдэд цахимаар болон цаасаар хүргүүлэхийн хамт 12 дугаар сарын байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

Шилэн дансны мэдээллийг байгууллага тус бүрээр хугацаандаа оруулж 4 дүгээр улирлын тайланг хугацаандаа илгээв.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын онлайн систэмд нийгмийн даатгалын тооцооны хүснэгтийг НД-7, НД-8 маягтуудаар 95 хүний тухайн сарын цалингийн мэдээллийг шивж илгээсэн. Татварын 1 дүгээр улирлын тайланг “e. tax.mn” хаягаар татварын албанд суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын тайлан 4, тогтмол бус үйл ажиллагааны орлогоос суутгасан мэдээ 4, цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан 4, ААНБ-ын хувь хүнд олгосон орлого албан татвар суутгаагүй албан татварын мэдээ 4, нийт 4 төрлийн 12 тайланг 4 дүгээр улирлын эцсийн байдлаар гаргаж хугацаанд нь хүргүүлэв.

Тайлант оны 1 дүгээр улиралд 25 аж ахуйн нэгж, 7 төсөвт байгууллага, 2 банк, төрийн бус байгууллага 3, шашны байгууллага 1, бусад 5 бүгд 43, нийт 138 татвар төлөгчөөс давхардсан тоогоор 245 тайлан хүлээн авч, тооцооллын алдааг шалган хариуцсан нягтлан бодогчийн хамт программд шивж баталгаажуулан тайлангийн тасалдалгүй ажиллаа.

Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайлангуудыг хүлээн авч ажиллаа. Нийт 55 иргэний тайлан хүлээн авсан ба үүнээс 19 нь Орон сууцны чөлөөлөлтөнд хамрагдах иргэд 46 нь сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэх

иргэн байсан ба ХХОАТ-ын тайланг бүрэн шивж баталгаажуулсан.

2017 оны 17289,80 төгрөгийн буцаан авалтын тайланг хүлээн авч, 325 иргэний ноосны урамшууллын болон урьдчилгаа татварын тайланг иргэн бүрээр цахим тайлангийн системд шивж хариуцсан байцаагчаар баталгаажуулав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР